



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайншанд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/72/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Дорноговь аймаг
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Аудитын менежер:

Утас: 70523020

Ахлах аудитор:

Аудитор:

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

У.Оюунтүлхүүр

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Э.Энхцэцэг

Цахим хаяг: enkhsetsege@audit.gov.mn

Т.Мөнхтогтох

Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.07.22 № 1-6/75

танай _____ -ны № _____ -т

САЙНШАНД СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Д.ЭНХТАЙВАН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	5.4	3.8
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5.0	2.7
	Нийт хөрөнгийн дүн	10.4	6.5
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10.4	6.5
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10.4	6.5
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	97.1	99.9
	Үйл ажиллагааны зардлын дүн	97.3	103.9
	Үйл ажиллагааны үр дүн	-0.2	-4.0
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	-0.2	-4.0
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	97.1	100.4
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	96.7	99.8
	Үйл ажиллагааны ЦМГ	0.4	0.6
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-0.4	-0.6
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10.7	10.4
	Тайлант оны үр дүн	-0.3	-3.9
	Эцсийн үлдэгдэл	10.4	6.5
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	96.7	95.2
	Урсгал зардал	96.7	95.2
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	96.7	95.2
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	96.7	95.2
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сайншанд сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны эрхэм зорилго нь иргэддээ тулгуурласан чадвартай, хариуцлагатай нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг төлөвшүүлж, хөгжүүлэх.

Байгууллагын 2021 онд дэвшүүлсэн зорилт:

- Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх;
- Тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэх, иргэдийн дунд соён гэгээрүүлэх сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах;
- Төлөөллийн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж, иргэдийн итгэлийг бэхжүүлнэ.

Үйл ажиллагааны чиглэл нь: Төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа юм.

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 149 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Тав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1.1 сая төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс, 1.1 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор балансаас балансад шилжиж ирсэн 1.1 сая төгрөгийн 2 хөрөнгийг санхүүгийн тайланд бүртгээгүй байсныг залруулав.

Албан шаардлага

Өмнөх аудитаар өгсөн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн бүртгэлтэй үндсэн хөрөнгийг шийдвэрлэх тухай зөвлөмжийг хэрэгжүүлээгүйд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Зөвлөмж

1 Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Цалинг холбогдох зааврын дагуу бүртгээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн “6.3.2 санхүүгийн аливаа үйл ажиллагааг НББОУС-ын дагуу цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэж тайлагнах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 1 дүгээр хавсралтын 3.6 дахь заалттай нийцэхгүй байна.

Цалингийн бүртгэлийг холбогдох зааврын дагуу хийж байх.

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Сайншанд сумын ИТХ	3	1.1	1	1.1	-	-	1	-	1	-
	НИЙТ	3	1.1	1	1.1	-	-	1	-	1	-